



ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР  
ИРГЭНИЙ НИСЭХИЙН  
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ДАРГЫН  
ТУШААЛ

2021 оны 05 сарын 19 өдөр

Дугаар А/131

Улаанбаатар хот

Ажил хүлээн авах комисс томилох  
тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 10 дахь заалт, Иргэний хуулийн 351 дүгээр зүйлийн 351.1.2 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Холбоо, навигаци, ажиглалтын албаны инженер, техникийн ажилтнуудын хөдөлмөр хамгааллын хувцас нийлүүлэх Багц-1: Өвлийн хувцас, зуны хувцас, Багц-2: Өвлийн гутал, зуны гутал нийлүүлэх ИНЕГ/УЗ/ТББ/Б-25/20 дугаартай гэрээт ажлыг хүлээн авах комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай. Үүнд:

Комиссын дарга:

Х.Ганбаатар

Холбоо, навигаци, ажиглалтын албаны  
Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн  
хэсгийн дарга

Гишүүд:

Д.Оюунболд

Холбоо, навигаци, ажиглалтын албаны  
Холбооны хэсгийн радио холбооны тасгийн  
ахлагч инженер

Д.Эрдэнэ

Холбоо, навигаци, ажиглалтын албаны  
Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн  
хэсгийн хөдөлмөрийн хамгааллын ахлах  
инженер

Э.Энхжин

Худалдан авах ажиллагааны тасгийн  
мэргэжилтэн

С.Энхжаргал

Үйлдвэрлэлийн нягтлан бодох бүртгэлийн  
албаны нягтлан бодогч

2. Дээрх барааг гэрээнд заасан тоо хэмжээ, техникийн тодорхойлолт, холбогдох баримт бичигт дурдсан шаардлагуудын дагуу шалган хүлээн авах, санхүүгийн бүртгэлд тусгуулах, комиссын акт, холбогдох бусад материалыг бүрдүүлж, 2021 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн дотор Худалдан авах ажиллагааны тасагт хүргүүлэхийг ажил хүлээж авах комисс (Х.Ганбаатар)-т үүрэг болгосугай.

ДАРГА



П.МӨНХЖАРГАЛ

1721 01 1020